

# ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 03 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

## Нэг. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, ажлын албаны хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Ажлын албанаас 2019 оны 3 дугаар сард дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд:

Энэ сард аймгийн ИТХ-ын ээлжит XII хуралдаан, Тэргүүлэгчдийн ээлжит бус II, III, ээлжит V-р хуралдаанууд хуралдлаа.

### ИТХ-ын XII хуралдаанаар:-

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний хэрэгжилтийн явцын тайлан, мэдээлэл, түүнд Хурлын Хороодоос хийсэн дүгнэлт, Хурлын Төлөөлөгчдөөс гарсан саналыг хэлэлцээд "Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 112 зорилт, 378 арга хэмжээг аймаг, сумдын түвшинд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, эдийн засаг, нийгмийн салбаруудын цаашдын хөгжлийн чиглэлийг тодорхойлсон 27 бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2. "Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл"-ийн биелэлтийн тайлан, мэдээлэл, түүнд Хурлын хороодоос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд дэвшүүлсэн 141 зорилт, 526 арга хэмжээг хэрэгжүүлж аймгийнхаа хөгжлийг хангах, иргэдийнхээ ая тухтай амьдрах нөхцөлийг улам сайжруулах чиглэлээр олон чухал арга хэмжээг хэрэгжүүлж, нийт иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын идэвхи санаачлагыг өрнүүлж, оролцоо, дэмжлэгийг өргөжүүлэх зорилгоор 2018 оныг "Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих жил" болгох уриа дэвшүүлэн, төлөвлөсөн ажлаа 93.92 хувиар биелүүлж зохих амжилт, үр дүнд хүрч байна.

3. Газрын харилцааны талаар 2018 онд хийсэн ажлын чиглэлийн хэрэгжилт, 2019 онд хийх ажлын чиглэлийн тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, тэдгээрт Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд "Аймгийн газрын харилцааны талаар 2018 онд хийх ажлын чиглэл"-ийн зорилт, арга хэмжээг 88.6 хувийн биелэлттэй байх тул "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэн, "Аймгийн газрын харилцааны талаар 2019 онд хийх ажлын чиглэл"-ийг батлав.

4. Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулсан тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, түүнд Хурлын Байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд батлав.

5. Эрдэнэ сумын хилийн цэсд өөрчлөлт оруулах санал боловсруулсан тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөлд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Төв аймгийн Эрдэнэ сумын нийслэл Улаанбаатар хоттой залгаа хилийн цэсд өөрчлөлт оруулан шинэчлэн тогтоолгох саналыг дэмжиж "Эрдэнэ сумын хилийн цэсд өөрчлөлт оруулах санал уламжлах тухай" Хуралдааны 05 дугаар тогтоолыг батлан Монгол улсын Засгийн газарт уламжлав.

**Тэргүүлэгчдийн ээлжит бус-II хуралдаанаар:-** 2019 оны 3-р сарын 04-ний өдөр хуралдсан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус 2 дугаар хуралдаанаар аймгийн ИТХ-ын ээлжит 12 дугаар хуралдааны товыг өөрчлөв.

**Тэргүүлэгчдийн ээлжит бус-III хуралдаанаар:-** Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит бус 3 дугаар хуралдаан нийт 7 асуудал хэлэлцэж 2 тогтоол батлан 5 асуудлыг Хурлын Хуралдаанд шилжүүлэв.

**Тэргүүлэгчдийн ээлжит V хуралдаанаар:-**Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ээлжит 5 дугаар хуралдаанаар нийт 7 асуудал хэлэлцэж 5 тогтоол батлан хуралдааны тэмдэглэлээр 2 үүрэг өгөв.

Төв аймгийн Баянчандмань сумаас аймаг, сумын ИТХ-д сонгогдсон төлөөлөгч хамтран “Төлөөлөгчдийн өдөр” арга хэмжээг зохион байгуулж, өнгөрсөн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлууд болон цаашид хийгдэх ажлынхаа тухай танилцуулж, иргэдийнхээ асуултанд хариулт өгч, тулгамдсан асуудлуудыг сумын удирдлагуудтай хамтран шийдвэрлэж ажиллалаа.

Аймгийн ИТХ-ын Ажлын албанд сумдын ИТХ-аас 3 сарын ажлын тайлангаа Өндөрширээт, Баян-Өнжүүл, Баяндэлгэр, Алтанбулаг, Баян сумд ирүүлсэн байна.

### **Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:**

Нутгийн удирдлагын хүрээнд: Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал 1 удаа хуралдаж 6 асуудлыг хэлэлцэн холбодох шийдвэрийг гарган ажилласан.

Орон нутгийн удирдах ажилтны зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 1 дүгээр улирлын байдлаар гарган ЗГХЭГ-т хүргүүллээ.

Монгол Улсын Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан “Батламж”, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргын аймгийн Засаг даргатай 2019 онд хамтран ажиллах гэрээний заалтуудыг хяналтад авч, эзэнжүүлэв.

Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудал хариуцсан хэлтэс, агентлагуудаас багийн ИНХ-д оролцох хуваарь, саналыг авч нэгтгэн гүйцэтгэлд хяналт тавьж байна.

Баянцагаан, Лүн, Өндөрширээт, Угтаалцайдам, Эрдэнэсант сумын тус бүр нэг “Явуулын баг”-г шаардлагатай 6.0 сая төгрөгийн техник, тоног төхөөрөмжийн үнийн судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлээд байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, аймгийн ЗДТГ-ын 2019 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны 03 дугаар сарын 20-26-ны өдрүүдэд Аргалант, Баян, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Өндөрширээт, Сүмбэр сумын ЗДТГ, төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн тусалж, шаардлагатай сургалт, зөвлөмжийг газар дээр нь өглөө.

ТЗУХ, ТАЗСЗ-өөс “Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/”, түүнийг дагаж мөрдөх “Шинэчилсэн дүрэм, журам”-ын талаар нэгдсэн ойлголт өгч, хэрэгжилтийг хангуулах зорилгоор анхан шатны мэдлэг олгох сургалтыг 17 байгууллагын 650 албан хаагчид хийсэн.

№	Сургалт зохион байгуулсан хугацаа	Сургалтад хамрагдсан	
		Байгууллага, албан тушаалтан	ТАХ-ийн тоо
1	2019.01.21	Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга нар	81
2	2019.01.21	Сумдын ИТХТ-ийн нарийн бичгийн дарга нар	27
3	2019.01.25	Биеийн тамир, спортын газрын албан хаагчид	14
4	2019.02.26	Зуунмод сумын ЗДТГ-ын албан хаагчид, төсөвт байгууллагын дарга нар	31
5	2019.02.27	БСУГ, соёлын салбарын албан хаагчид	22
6	2019.02.28	ГХБХБГ-ын албан хаагчид	35
7	2019.02.28	27 сумын ЗДТГ-ын дарга, бусад удирдлага	32
8	2019.03.01	Мал эмнэлгийн газрын албан хаагчид	30
9	2019.03.01	Санхүүгийн хяналт, аудитын албаны албан хаагчид	7

10	2019.03.04	Монгол туургатан театрын албан хаагчид	36
11	2019.03.13	Баянчандмань сумын “ТАХ-чдын зөвлөгөөн”-д оролцогчид	130
12	2019.03.14	ХХААГ, сумдын ХАА-ын тасгийн дарга, мэргэжилтнүүд	64
13	2019.03.21	Сүмбэр сумын төсөвт байгууллагын албан хаагчид	40
14	2019.03.22	Өндөрширээт сумын төсөвт байгууллагын албан хаагчид	32
15	2019.03.22	Баян-Өнжүүл сумын төсөвт байгууллагын албан хаагчид	22
16	2019.03.25	Аргалант сумын төсөвт байгууллагын албан хаагчид	30
17	2019.03.25	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын албан хаагчид	17
<b>НИЙТ ДҮН</b>		<b>17 байгууллага, нэгж</b>	<b>650</b>

Мөн сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар дээд шатны байгууллагын санал дүгнэлт ирсэн 26 иргэн /үүнээс 11 ТАХ/-ий тодорхойлолтыг хэлэлцүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжилсан. Шагналын төрлөөр авч үзвэл:

№	Шагналын төрөл	Дэмжсэн тодорхойлолтын тоо	Үүнээс ТАХ-ийн тоо
1	“Гавьяат механикжуулагч”-цолоор	2	
2	“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор	1	
	“Цэргийн гавьяаны”- одонгоор	2	
3	“Алтан гадас одон”-оор	11	4
4	“Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар	10	7
<b>НИЙТ ДҮН</b>		<b>26</b>	<b>11</b>

2019 оны 1 дүгээр улирлын өссөн дүнгээр аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 27 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 38 иргэнийг шагнаж, урамшууллаа.

Төрийн албаны стандартын хүрээнд: Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 21 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын хүрээнд 21 сум, 9 байгууллагын төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах саналыг нэгтгэж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангав.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу төсөвт байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр ажлын хэсэг байгуулж, төрийн албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлтийг шинэчилэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж байна.

Удирдлагын академийг төгссөн, төрийн албанд ажиллаж байгаа төгсөгчдийн мэдээллийг бүртгэх ажиллагааг тус академитай хамтран явуулж байна.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 255 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу хүний нөөцийн нэгдсэн программд цалин хөлс, бусад хөдөлгөөний мэдээллийг шинэчлэх ажлыг хийж дуусгалаа.

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2019 оны 17 тоот албан бичгийг төрийн байгууллага, албан тушаалтанд хүргүүлж чиглэл, зөвлөмж өгөв.

Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулагдсан албан тушаалын тодорхойлолт боловруулах ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулж, календарчилсан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Салбар зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn) цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.03.27-ны байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	6
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	-
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	-
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-
<b>НИЙТ ДҮН</b>		<b>6</b>

2019 оны 03 дугаар сарын 27-ны байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэр-лэсэн	Хүлээг-дэж буй	Шийдвэр-лэлтийн хувь
1	Албан бичиг	83	15	13	2	86.6
2	Өргөдөл, гомдол	4	4	2	2	50.0

Тайлант хугацаанд эрх хэмжээний хүрээнд 17 албан бичиг гадагш явуулсан.

Мерит төсөлтэй хамтран “Харилцаа хандлага, багийн хамтын ажиллагаа” сэдэвт сургалтыг аймгийн ЗДТГ-ын 40 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. Аймгийн ЗДТГ-ын 2019 оны Б/13 дугаар тушаалаар ЗДТГ-ын хэлтэс, албадын дарга, албан хаагчдын 2019 оны ээлжийн амралтын хуваарийг батлуулав.

Гадаад харилцаа: Аймгийн Музейн захирал, Нийтийн номын сангийн захирал, Эрдэнэ сумын Соёлын төвийн эрхлэгч нар аймгийн шууд харилцаат Япон улсын Тоттори мужид 2019 оны 3 дугаар сарын 03-08-ны өдрүүдэд төрийн албан хаагчийн богино хугацааны танилцах дадлагад хамрагдсанаар цаашид 2 талын ижил төстэй байгууллага хоорондын харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөл бүрдлээ.

БНСУ-ын Захирагч нарын Холбооны К2Н хөтөлбөрийн 2019 оны тэтгэлэгт сургалтад аймгийн Статистикийн хэлтсийн ахлах статистикч С.Батбаярыг 2019 оны 4 дүгээр сараас эхлэн 6 сарын хугацаанд хамруулахаар болсон.

БНСУ-ын Кангвон мужийн Гал унтраах албанаас аймгийн Онцгой байдлын газарт буцалтгүй тусламжаар хандивлах гал унтраах авто машинуудын хил гаалийн бичиг баримтын бүрдүүлэлт хийж, хүлээн авахаар бэлтгэж байна.

БНСУ-ын Кангвон мужийн Газар тариалангийн техник технологийн судалгааны хүрээлэнгийн 3 мэргэжилтэн 2019 оны 3 дугаар сарын 4-7-ны өдрүүдэд Төв аймагт ажиллаж, Зуунмод сумын “Агро парк” төслийн ажлын төлөвлөгөө, санхүүжилтын асуудлаар хэлэлцэн харилцан тохиролцсон. БНСУ-ын Кангвон мужийн тус хүрээлэнд 4 дүгээр сарын 8-23-ны өдрүүдэд болох “Хүлэмжийн тариалалтын шинэ технологийн сургалт”-д газар тариалангийн мэргэжилтэн, өрхийн тариалан эрхлэгчдын 7 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг хамруулахаар бэлтгэл хангаж байна.

БНХАУ-ын Жилинь мужтай хамтарч хэрэгжүүлэх 2019 оны “Төрийн албан хаагч солилцооны тэтгэлэгт хөтөлбөр”-т Эрдэнэсант сумын Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн мэргэжилтэн Л.Атарбаярыг 2019 оны 3 дугаар сар эхлэн 10 сарын хугацаатай суралцуулахаар бэлтгэл хангаж байна.

Аймгийн Онцгой байдлын газрын дарга, “Төв АЗЗА” төрийн өмчит Хувьцаат Компаний гүйцэтгэх захирал нар 2019 оны 3 дугаар сарын 5-8-ны өдрүүдэд Япон улсын

Хёго мужийн Кобе хотод болсон Зүүн Хойд Азийн Нутгийн захиргааны холбооны Гамшгаас сэргийлэх хорооны 17 дугаар хуралд оролцов.

Мэдээлэл технологийн чиглэлээр: Төсөвт байгууллага, 27 сумын цахим хуудас мэдээллийг цахим архивт авч дууссан бөгөөд цаг үеийн асуудлаар 2 удаагийн цахим хурал зохион байгуулах бэлтгэл хангалаа.

Хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр, иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд: Төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, МУЗГ-ын 2005 оны 67 дугаар тогтоол /захирамж/, аймгийн Засаг даргын 2017 оны А/131 дугаар захирамжаар баталсан “Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ыг удирдлага болгон шийдвэрлэж байна.

Аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын 3.1.1-д заасны дагуу “Иргэдтэй уулзах цаг”-ийг Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд “Лхагва” гараг бүрийн 10:00-13:00 цагийн хооронд зохион байгуулж байна. Өссөн дүнгээр 11 удаагийн уулзалтаар давхардсан тоогоор 90 иргэний 149 санал, хүсэлт, гомдол, асуулт, шүүмжлэлийг хүлээн авч 45 албан бичиг төлөвлөн холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, 35 санал, хүсэлт, асуултын хариуг иргэнд шууд өгч, 44 санал, хүсэлт шийдвэрлэх шатандаа хүлээгдэж, шийдвэрлэлт 70,47% байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн ажлын төлөвлөгөөнөөс аймагт хамааралтай 32 заалтын 1 дүгээр улирлын биелэлт 43% хувьтай байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2019 оны 02 дугаар сарын 28-ний байдлаар Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 27 байгууллага 330 гаруй төрлийн үйлчилгээг 7500 иргэнд, өдөрт дунджаар 450-500 иргэнд шуурхай хүргэн ажиллаа.

Аймгийн веб сайтад **31** мэдээ мэдээлэл, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **53** мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **5** дугаар, мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар давтагдсан тоогоор нийт **57** мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэлээ.

Тус төвд аймгийн Орон нутгийн өмчийн газрын тендерийн нээлт, Байгаль орчин аялал жуулчлалын газраас “Дэлхийн усны өдөр”-т зориулан нээлттэй өдөрлөг, “Нүүрснээс байгалийн нийлэг хий гаргах үйлдвэрийн төсөл”-ийн хэлэлцүүлгүүд зохион байгуулагдаж иргэд мэдээ мэдээлэл өгсөн.

7 хоног бүрийн “Лхагва” гаригийн 10:00-13:00 цагийн хооронд аймгийн удирдлагууд 22 иргэнтэй уулзаж, 51 санал хүсэлт хүлээн авсан. Харин 7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой 4 гомдол санал ирснийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлсэн.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: Төв аймгийн Заамар суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийн үйл зогсоох 4 акт, зөрчил дутагдал гаргасан 3 аж ахуйн нэгжид 33 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг авлаа. Мөн зөрчил дутагдлыг арилгах зорилгоор 2 аж ахуйн нэгжид 5 заалт 2 албан шаардлага хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд эмчилгээ, эм биобэлдмэл, эрүүл ахуй, халдвар хамгаалал, хүнс, ургамал хамгаалал, хорио цээр, боловсрол соёл, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, хэмжил зүй, харилцаа холбоо, эрчим хүч, барилга, тээвэр, газар, геодези, байгаль орчны хяналтын чиглэлээр төлөвлөгөөт шалгалтыг Эрдэнэ, Баяндэлгэр, Архуст, Мөнгөнморьт Зуунмод, Жаргалант, Борнуур зэрэг сумдын 37 аж ахуйн нэгж.

байгууллагад зөвлөн хийж, улсын байцаагчийн 12 албан шаардлагаар үүрэг өгсөн. Тус сумдын ундны усны эх үүсвэр болон сургууль, цэцэрлэгийн ундны уснаас хими, нян судлалын 14 дээж авсан.

Төв аймгийн Барилга захиалагч орон сууцны корпораци ОНӨААТҮГ-ийн 2019 оны 02-р сарын 20-ны №32 тоот хүсэлт, аймгийн МХГ-ын даргын 2019 оны 02-р сарын 25-ны өдрийн 19/29 дугаартай удирдамжийн хүрээнд Аргалант, Архуст, Баянхангай, Баянцогт сумдад тавигдсан утасгүй интернетийн төхөөрөмжийн суурилуулалт, ашиглалтад төлөвлөгөөт бус шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага өглөө.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн чиглэлээр “Кинг”, “Баян булаг” интернет тоглоомын газрын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийж, хугацаатай албан шаардлага өгч ажилласан.

МХЕГ-ын даргын баталсан 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/108 тоот удирдамжийн хүрээнд Төв аймгийн Заамар сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Эко алтан заамар” ХХК-ийн ил уурхайн талбайд гарсан осолд нэрвэгсдийг гаргаж авах ажиллагаанд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаж, аюулгүй байдлыг хангах хүртэл хугацаагаар “Эко алтан Заамар” ХХК-ийн Баянголын эх уурхайн үйл ажиллагааг зогсоосон.

Тайлант сард төлөвлөгөөт хяналт шалгалт, ААН иргэний хүсэлтийн хүрээнд 312 сорьцыг хүлээн авч 1429 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулж, хугацаа хэтрүүлэхгүй олгосон. Шинжилгээгээр хүнсний улаан буудайн 73 сорьц 113 үзүүлэлтээр стандартын шаардлага хангаагүй гарсан.

Онцгой байдлын газрын хүрээнд: Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчин үүсч байгуулагдсаны яруу алдарт 98 жилийн ойг тохиолдуулан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд **“Эх орны төлөө-2019”** цогцолбор тэмцээнийг амжилттай зохион явууллаа.

МУЗГ-ын 2018 оны 114 дүгээр тогтоолоор Төв аймгийн Мөнгөнморьт суманд” Гал түймэр унтраах аврах IV зэрэглэлийн 75 дугаар анги”, Батсүмбэр суманд “Гал түймэр унтраах, аврах анги”, Лүн болон Баян сумдад “Эрэн хайх, аврах бүлэгт аймгийн Засаг даргын санхүүжилтээр шуурхай албаны УАЗ-Фургон автомашиныг хүлээлгэж өгсөн.

Тус газраас 2019 онд **“Сахилга хариуцлагатай, хурдтай үр дүнтэй ажилцаага”**-уриалгыг дэвшүүлсэн бөгөөд ажлын цаг ашиглалт, ажлын байрны цэвэрлэгээ, албан хаагчдын ажил үүргийн биелэлт, сахилга ёс зүй, дэг журам, цэрэгжилч жагсаалч байдалд тогтмол хяналт тавьж, 7 хоног бүрийн “Даваа” гаригийн 08:00-08:40 цагт үзлэг шалгалт хийж хэвшлээ.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 27 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 91 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 24 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтанд заавар зөвлөгөөг өглөө.

“Үзвэр үйлчилгээ, соёл урлагийн” байгууллагуудад галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтыг удирдамжийн дагуу 5 байгууллагад явуулахад 36 зөрчил илэрч, улсын хяналтын байцаагчийн ЗБАШ-5 бичиж холбогдох байгууллагын албан тушаалтанд хүргүүлэв.

Зуунмод сумын 1 дүгээр баг, нефтийн задгайд баригдах хаан банкны тооцооны төвийн барилга, 6 дугаар багт баригдах 30 айлын орон сууцны барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 200,000 төгрөгийг төвлөрүүлсэн.

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар албан даалгаврын хэрэгжилт, хяналт шалгалт хийх ажлын хэсгийн удирдамжийн хүрээнд Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Баянчандмань сумдад ажиллаж, мэргэжил арга зүйн зааварчилгаа өгөв.

2019 оны 03 дугаар сард объектын гар түймэр 3, үйлдвэрлэлийн осол 1 бүртгэгдэн шалгагдаж байна.

МУЗГ-ын 2017 оны 67 дугаар тогтоолын дагуу “ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН АЮУЛЫГ ИРГЭД ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ” дадлага сургалтыг Зуунмод сум дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд зохион байгуулж, 6 ангийн 120 сурагч, 35 багш ажилчдыг хамруулав.

“Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-ыг хэрэгжүүлэх дадлага сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 16:00 цагт хийхэд 27 сумын нийт 8480 хүн, 393 автомашин тээврийн хэрэгсэл, давхардсан тоогоор 107 аж ахуй нэгж хамрагдаж, орон нутгийн гамшгаас хамгаалах албад, аж ахуй нэгж байгууллагын хүн бүрийн бэлтгэл бэлэн байдлыг шалгасан.

### **Гурав. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:**

Аймгийн Засаг дарга болон сумын Засаг дарга нарын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээнд төсвийн сахилга хариуцлагын тухай 7 үүрэг өгч, хэрэгжүүлэн ажиллаж байна. 2019 оны эхний 2 сарын байдлаар төсвийн зарлага 14,0 тэрбум төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 10,7 тэрбум төгрөг болж, 75,5%-ийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн төсвийн орлого мөн оны 2 сарын байдлаар 278,0 сая төгрөгөөр тасарч байгаатай холбогдуулан төсвийн урсгал өр 273,9 сая төгрөг байна. Татварын орлого бүрдүүлэлт, татварын дутуу төлөлтийг барагдуулах ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны А/157 дугаар захирамж гарган 2 сарын аян зохион байгуулж, үр дүнг тооцож байна. Тус аяны хүрээнд усны төлбөрийн орлого 235,1 сая төгрөг, цалингийн ашиг 57,6 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн татвар 8,0 сая төгрөг нийт 300,7 сая төгрөгийг татварын дутуу төлөлтөөс төсөвт төвлөрүүлээд байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх 163 хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох цахим хуудас, мэдээллийн бусад эх үүсвэрт ил тод байршуулан нийтэд хүргэж байна. 2019 оны 3 дугаар сарын байдлаар аймаг, сумын орон нутгийн хөгжлийн санд 541,3 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгосон.

Орон нутгийн хөгжлийн сангийн шинэчилсэн журмыг хэрэгжүүлэх зорилгоор “Тогтвортой амьжиргаа төсөл”-тэй хамтран сум тус бүрээс 10 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй сургалтыг 2019 оны 3 дугаар сарын 11-30-ны хооронд зохион байгуулж байна.

### **Дөрөв. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:**

2019 оны 3 дугаар сард “Үйлдвэрлэл үйлчилгээтэй холбогдох хууль журам” сурталчлах 14 хоногийн аян зохион байгуулж байна. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд бүтээсэн 15 төрлийн богино шторк, 6 төрлийн богино хэмжээний кино, иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг түгээдэг “[e-khutuch.mn](http://e-khutuch.mn)” цахим хуудас, Хууль зүйн Луужин 1 пейж хуудсын танилцуулга шторк зэргийг орон нутгийн телевиз, төсөвт байгууллагуудын ЛЭД дэлгэц, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд хүргэж байна.

Аймгийн ГХУСАЗСЗ-өөс 03 дугаар сарын 14-ний өдөр “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх нь” сэдэвт нэгдсэн сургалтыг иргэний хяналтын зөвлөл, 27 сумын ГХУСАЗСЗ, гишүүд буюу 140 гаруй албан хаагчдын хамруулан зохион байгууллаа.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 03-р сарын 25-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус ажлын хэсгийг байгуулж, ажиллах журмыг батлуулав.

“Аймгийн нутаг дэвсгэрт шашны сүм, хийд байгуулахад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж, ажлын хэсгийн хурлаар танилцууллаа.

“Глоб Интернэшнл төв” ТББ-аас хэрэгжүүлж буй “GSP+ механизмаар дамжуулан хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийг орон нутгийн бизнес эрхлэгчид, төрийн болон төрийн бус байгууллагад танилцуулах зорилгоор “Орон нутгийн бизнес Европын холбооны зах зээлд гаргах боломж” сэдэвт уулзалтыг аймгийн төвд зохион байгуулж, нийт 8 байгууллагын 37 төлөөллийг оролцуулж, санал солилцлоо.

Архивын үйлчилгээ: Тайлант хугацаанд 188 хөмрөгийн 963 хадгаламжийн нэгж ашиглан архивын эх баримтаас 175 иргэний хүсэлтээр 302 хуулбар хувь, 114 лавлагааг гаргаж үйлчилсэн бөгөөд 1.106.900 төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэв.

3 хөмрөгийн 235 хадгаламжийн нэгжийн 6313 хуудас баримтын 13122 хүний нэр, 5187 заалтын тоо, 5186 тушаалын тоон мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, 3 хөмрөгийн 70 хадгаламжийн нэгжийн 6319 хуудас баримт скайнердаж 3 хөмрөгийн 70 хадгаламжийн нэгжийн 5187 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 5187 заалтын 6319 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбон цахим бааз үүсгэлээ. 2 хөмрөгийн 235 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалт хийсэн.

Улсын бүртгэлийн үйлчилгээ: 2019 оны 03 дугаар сарын байдлаар эд хөрөнгийн бүртгэлийн цахим санд нийт 48746 хувийн хэрэг байгаагаас үл хөдлөх/газраас бусад/ - 9383, Газар өмчлөх эрхийн -39363 хувийн хэрэг байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 14418. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 28.6 сая төгрөг, үл хөдлөх худалдан борлуулсны орлогоос 1.3 сая төгрөгийг тус тус улсын төсөвт орууллаа.

Тайлант хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 68 аж ахуй нэгж, байгууллага бүртгүүлж, 36 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 9, хууль хяналтын байгууллагад 12 лавлагаа мэдээлэл өгч, 4.8 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт орууллаа.

Цагдаагийн газрын ажил ажиллагааны хүрээнд: 2019 оны эхний 2 сарын байдлаар 49 холбогдогчтой, 566.9 сая төгрөгийн хохиролтой **130** гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25 хэргээр буюу **19.2** хувиар өссөн байна. Хөнгөн гэмт хэрэг 101 бүртгэгдсэн нь 31 нэгжээр буюу 30.7 хувиар, хэрэг бүртгэлтийн гэмт хэрэг 91 бүртгэгдсэн нь 9 нэгжээр буюу 9.9 хувиар, мөрдөн байцаалтын гэмт хэрэг 39 бүртгэгдсэн нь 16 нэгжээр буюу 41.0 хувиар тус тус өссөн, хүнд гэмт хэрэг 29 бүртгэгдсэн нь 6 нэгжээр буюу 17.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн үйлдэгдсэн байдлаас үзэхэд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 26.7 хувиар, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 56.2 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 75.0 хувиар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэмт хэрэг 100.0 хувиар тус тус өссөн, аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 33.3 хувиар буурсан, галт зэвсэгээр үйлдэгдсэн гэмт хэрэг, хүүхэд оролцсон гэмт хэргүүд урьд оны мөн үетэй харьцуулахад ижил түвшинд байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 27.5 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 хувиар өссөн. Улсын дундаж 12.9 хувьтай гарсан ба Улсын дунджаас 14.6 хувиар өссөн дүнтэй байна.

Баянхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн 32 багш ажилчид, 6-12 дугаар ангийн 128 сурагч, Улсын иргэний бүртгэлийн хэлтсийн 20 төрийн албан хаагч, Лүн, Алтанбулаг сумдын малчдын бүлгийн 184 малчдад “Хулгайлах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт зохион байгуулсан. Мөн Цагдаагийн газрын “Эрүүлжүүлэх саатуулах байр”-д шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан давхардсан тоогоор 28 иргэнд “АА нийгэмлэг”-ийн 14 гишүүнээр “Архинд донтох эмгэгээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр 2 удаагийн сургалт явуулсан.



Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран мэдээ, мэдээллийг цаг тухай бүр нь солилцон, нөхцөл байдлыг үнэлж Төв аймгийн “Төв”, “ТBS” телевизэд арга хэмжээний талаар сурталчилж, ард иргэдэд анхааруулга, сэрэмжлүүлэг мэдээлэл 12 удаа нэвтрүүлсэн. Мөн “Халаасны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Авто машины хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Орон байрны хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Камерын хяналт”, “Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сэдэвт зурагт хуудас, видео шторкийг “Төв”, “ТBS” телевизүүдээр өдөр бүр 3 удаагийн давтамжтай, Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааруулга нэвтрүүлэг 1 удаа тус тус бэлтгэн иргэдэд хүргэсэн.

Гудамж талбай, олон нийтийн газар болон гэр орон, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгслэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон, шүүхээр баривчлагдсан, албадан саатуулагдсан нийт 78 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд хүлээн авснаас эрүүлжүүлэгдсэн-38 иргэн, албадан саатуулсан-11 иргэн, шүүхээр баривчлагдсан-29 иргэнд код журмын дагуу биед болон эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авч ажилласан. Эрүүлжүүлэгдсэн 38 иргэнээс 408.500 төгрөгийн торгуулийг төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн бөгөөд төлбөр төлөлт 100%-тай.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 52 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хөдөлгөөнд оролцсон 11 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэж ажиллалаа. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 4002 жолоочийг 137.0 сая төгрөгөөр торгов.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд Криминалистикийн шинжилгээ-51, магадлан шинжилгээ-43, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-125, гарын мөрийн санг баяжуулсан-52, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 169 гаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
03-р сар	398	162	5	555	129	426	23.2%
	3920610.2	1736813.5	404173.8	5253249.9	731043.2	4522206.7	

**Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:**

“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг гаргаж 2019.03.19-ний өдөр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар, 2019.03.25-ны өдөр ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлээ.

2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр “Мерит” төсөл болон Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран “Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт ба хяналт-шинжилгээ, үнэлгээ: шалгуур үзүүлэлт боловсруулах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус сургалтад Дундговь, Дорнод, Сүхбаатар аймаг, УУХҮЯ, БОАЖЯ, Ашигт малтмал, газрын тосны газар, Татварын ерөнхий газар, Цэнгэг усны нөөц байгаль хамгаалах төв зэрэг байгууллагаас 30 албан хаагч хамрагдлаа.

Нийгмийн салбарын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааны тайлан мэдээллийг Зуунмод сумын 65 ахмадад танилцуулах ажлыг 3 дугаар сарын 21-ний өдөр зохион байгууллаа.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: Аймгийн Засаг даргын ивээл дор “Төв математик-ҮИ” олимпиадыг Баянчандмань суманд 2019 оны 03 дугаар сарын 11, 12-

ны өдрүүдэд 7 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Олимпиадад аймгийн ЕБ-ын 30 сургуулийн 32 багийн 4-12-р ангийн 243 сурагч, бага анги, математикийн 88 багш, 29 удирдах ажилтан, нийт 360 төлөөлөл оролцон, оюун ухаан авхаалж самбаагаа сорин уралдаж, тэргүүний сургууль, багш, сурагчдаа тодруулан 5.2 сая төгрөгийн урамшуулал олгосон. Энэ үеэр “Математикч сургууль–2018” болзолт уралдааны шалгуур хангасан Баянчандмань сумын ЕБС-ийг 2 сая төгрөгөөр, Заамар сумын ЕБС-ийг 1.5 сая төгрөгөөр, мөн 3 багшийг 1.2 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа. Олимпиадын даалгаврын гүйцэтгэл 40.2%-д хүрч өмнөх оноос 7.01 хувиар өслөө.

“ЕБС-ийн удирдах ажилтны туршлага солилцох” зөвлөгөөнийг Баянчандмань суманд 3 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулж, 29 сургуулийн захирал, сургалтын менежерүүдийг хамруулж, “байгууллагын удирдлагын манлайлал”, “багшаа хэрхэн чадваржуулах”, “хүнээр хүн хийх”, “харилцаа хандлагаа хэрхэн өөрчлөх”, “байгууллагыг аж ахуйн тооцоон дээр удирдах” арга барил сэдэвт сургалтууд хийн харилцан туршлага солилцсон.

2019 оны 03 дугаар сарын 16-ны өдөр МУБИС-ийн Дизайн зураг зүйн сургуульд зохион байгуулагдсан “Дизайн зураг зүйн улсын анхдугаар олимпиад”-д аймгийн багш, суралцагчид амжилттай оролцож Дүрслэх геометр Зураг зүй төрөлд II байр, Хувцас дизайн төрөлд III байр, Мульт медиа төрөлд III байр, График дизайн төрөлд IV байр, Багш Л.Өлзийхуяг IV байранд тус тус шалгарч мөнгө, хүрэл медаль хүртлээ.

Төв аймгийн соёл, урлагийн байгуулагуудын “Үндэсний болон дэлхийн олон үндэстний соёлын үзэгдэл, юмс, тэдгээрийн хөгжил хөдөлгөөний талаарх өргөн хүрээтэй мэдлэгт суралцах, хүний оюуны сэтгэлгээг соёл, урлагаар хөгжүүлэх” зорилгын хүрээнд 3 дугаар сарын 15-16 өдрүүдэд 94 ажилтан, албан хаагчид хамруулан “**СОЁЛ, УРЛАГ-СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ НЬ**” арга хэмжээ зохион байгуулав.

БСШУС-ын 2018 оны А/425 тоот тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын дагуу сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн түвшинг тогтоож суралцагсдын мэдлэг, чадвар тэдгээрийн хэрэглээний чадварыг бодитоор үнэлж, үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээ хийх судалгааг Борнуур, Зуунмод сумын “Хүмүүн”, 5-р сургуулийн 3, 9, 10-р ангийг сонгон авч, 27 сумын 9-р ангийн сурагчдыг бүрэн хамруулан 2019 оны 03 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд авлаа. Тус судалгаанд нийт 32 багш, ажилтан хянагч багшаар ажиллалаа.

Монгол хэл, бичгийн элсэлтийн ерөнхий шалгалтыг БҮТ-тэй хамтран 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр 12-р ангийн суралцагчдыг хамруулан зохион байгуулсан.

Албан бус насан туршийн боловсролын төвийн үйлчилгээ: Байгууллага, нэгжийн захиалгын дагуу “Монгол хэл бичгийн зөв бичих дүрэм, найруулга зүй” сургалтыг 1 байгууллагын 48, “Монгол бичгийн анхан шатны сургалт”-ыг 3 байгууллагын 73 албан хаагчид, “Эцэг эхийн хайр” лекцийг Борнуур сумын 200 хүүхэд, “Хорт зуршил” сэдэвт сургалтад Зуунмод сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 30 суралцагчид тус тус зохион байгууллаа.

Театрын үйлчилгээ: Тайлант хугацаанд аймгийн “Монгол туургатан театр”-аас 15 удаагийн урлаг, соёл, бусад арга хэмжээг амжилттай зохион байгуулан давхардсан тоогоор 5000 гаруй иргэд, төрийн албан хаагчид үйлчилсэн.

Музейн үйлчилгээ: Тайлант хугацаанд насанд хүрэгч-198, хүүхэд-115, нийт 313 иргэнд музейн үйлчилгээг үзүүлсэн. Аймгийн Засаг даргын 2018 оны А/660 дугаар захирамжийн дагуу түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллого явууллаа. Тооллогын дүнгээр нийт 4199 дэсийн 8463 ширхэг үзмэрийн 2541 дэсийн 4867 ширхэг үзмэр буюу 87.05%-ийг тоолоод байна. Сумдын соёлын төвийн эрхлэгч, номын санч нарт “Түүх, соёлын хөдлөх дурсгалын улсын тооллогын явц, анхаарах асуудал” сэдвээр сургалт явуулсан.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: Тайлант хугацаанд нь 457-н байнгын уншигч, 1466 ирэгсэд, нийт 1925 уншигчдад 4030 ном олгож уншуулсан. БСШУС-ын 2018 оны А/683 дугаар тушаалаар батлагдсан “Уншлагыг дэмжье” журмын хэрэгжилтийг хангах зорилгоор ЕБС-иудын дунд ном унших 1 сарын аяныг эхлүүлж, “Ном дотор зам бий”, “Монголын эмэгтэйчүүд”, “Номын санчдын ширээний ном”, “Бидний унших ном”, “Номтой нөхөрлөцгөө” зэрэг сэдэвчилсэн номын үзэсгэлэн, “Гар урлал”-ын дугуйлангийн хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн тус тус гаргаж **520** уншигч, иргэдэд үйлчиллээ. Улсын хэмжээний “Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан”-д Төвийн мэдээ сэтгүүлийн 2018 оны 5-11-р сарын 85 мэдээллийг zotero программд шивж оруулав.

Эх хэлнийхээ үгийн сангийн яруу сайхантай танилцах, богино өгүүллэгийг уран тод уншиж сурах арга барилыг эзэмшүүлэх, оюуны боловсрол олгох, авьяасыг нээн хөгжүүлэх, номтой нөхөрлүүлэх зорилго бүхий “Утгын чимэг” уран уншлагын уралдааныг “Эх орончдын өдөр”, Монголын зохиолчдын эвлэлийн 90 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулсан.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Тайлант хугацаанд улс, аймгийн чанартай 7 удаагийн 6 төрөлт уралдаан тэмцээн зохион байгуулж, 178 баг, 1902 тамирчин оролцож, аваалж самбаа, хурд хүчээ сорьлоо.

Монголын хүүхдийн спортын VI их наадамд аймгийн баг, тамирчид амжилтай оролцож, тэшүүрийн тэмцээнээс 8 алт, 2 мөнгө, 5 хүрэл, нийт 15 медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 2-р байр; цанын тэмцээнээс 3 алт, 11 мөнгө, 7 хүрэл, нийт 21 медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 2-р байр тус тус эзэлсэн. Монголын бүх ард түмний XV спартикадын өвлийн төрлөөр Төв аймаг улсын хэмжээнд 3-р байр эзэлж 4 сая төгрөгөөр шагнуулав. Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан олон улсын өсвөрийн аварга шалгаруулах тэмцээний чөлөөт бөхийн барилдаанаас 2 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр эзэллээ. Классик пауэрлифтингийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 4 алт, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байр эзэлсэн амжилттай байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: “Эх орончдын өдөр”-ыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой дараах уралдаан, тэмцээнийг амжилттай зохион байгууллаа. Үүнд:

- Эх орны халдашгүй дархан байдал, үнэ цэнийг мөнхөд сануулах, яруу сайхан эх хэл, өв их гайхамшигт соёлоороо үргэлж бахархах үзлийг хойч үе, хүүхэд залуучууддаа төлөвшүүлэх зорилгоор “Эх орончдын өдөр”-т зориулж **“Тусгаар тогтнол”** яруу найргийн наадам

- Аж ахуйн нэгж байгууллага, анги хамт олны дунд “Төрийн дууллаа хэн сайн дуулах вэ” уралдаан

- Насан хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн “Залуу эхчүүдийн манлайллын хөтөлбөр”-ийн хүрээнд өсвөр насны ээжийн бодит амьдралаас сэдэвлэн бүтээсэн “Дүүлэн нис охин минь” туужийн 14 хоногийн аяныг 27 сумын ЕБС-иудын хэмжээнд зохион байгуулсан. Туужийн нэгдсэн хэлэлцүүлэгт Зуунмод сумын ЕБ-ын 3 сургуулийн 150 гаруй сурагчдыг хамрагдлаа.

Хүүхдийн оролцооны байгууллагын “Өөрсдөө санаачилж, хамтдаа хийцгээе” 14-р чуулганы төлөөлөгч хүүхдүүдийн гаргасан уриалгын дагуу аймгийн Засаг дарга, хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүний 2019 оны А/03 дугаар захирамжаар “Хүүхдээ сонсох” өдрийг сар бүр зохион байгуулж байна. 3 дугаар сарын “Хүүхдээ сонсох өдөр”-ийг Зуунмод сум дахь МСҮТ-ийн 113 хүүхдийг оролцуулан зохион байгуулж 2 талархал, 7 саналыг хүлээн авч холбогдох газруудад хүргүүлсэн.

Үе тэнгийн сургагч багш бэлтгэх цуврал сургалтыг 02 дугаар сарын 26-наас 03 дугаар сарын 12-ны өдрүүдэд зохион байгуулж, 30 сурагчид гэрчилгээ олгосон.

“Гэр бүлийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Архуст, Баян, Сэргэлэн сумдын нийт 28 өрхөд ажиллаж, нөхцөл байдлын үнэлгээ хийн зайлшгүй шаардлагатай үйлчилгээний хэрэгцээг тодорхойлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Мөн Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэгийн Төв аймаг дахь салбартай хамтран “Өрхийн тэргүүний манлайлал” сургалтыг Эрдэнэ, Баяндэлгэр, Мөнгөнморьт, Сүмбэр, Баянчандмань, Борнуур сумдад зохион байгуулж, 217 иргэнийг хамрууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2019 оны 3 дугаар сарын байдлаар 5374 иргэнд 886.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 3351 иргэнд 201.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1497 иргэнд 153.5 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 253 ахмад настанд 39.7 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 217 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 24.4 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 2570 эхэд 91,7 сая төгрөгийн тэтгэмж, Алдарт эхийн одонтой 8914 эхэд 1199.5 сая төгрөг, алдар цолтой 180 ахмад настанд 28.7 сая төгрөг, 5059 ахмад настанд 417.1 сая төгрөгийн насны хишиг, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 14691 эхэд 660.0 сая төгрөгийн тэтгэмж тус тус олгосон.

“ХБХЭМБНХСК” тайлант сард 2 удаа хуралдаж, хөгжлийн бэрхшээлтэй 22 хүүхдийг байнгын асаргаатай болохыг тогтоож, СӨБ, ЕБС, Тусгай сургуульд 4 хүүхэд, 2 хүүхдийг ХБ болохыг тодорхойлсон. ХБИ-ийн төвд 31 иргэнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар төрөөс баримталж буй бодлого”, “Хүний эрхийн хандлага”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүй”, “Хөгжлийн бэрхшээлийн ниймгийн загвар ба хүртээмжтэй орчин” сэдэвт сургалтыг явууллаа.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд шинэ төрсөн 46 хүүхдийн мэдээллийг бүртгэж, Зуунмод сумын 70 өрхийг судалгаанд хамруулж, 68 өрхийн судалгааг програмд шивж баталгаажуулсан.

Тайлант сард 23 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, ажилд зуучлагдсан 6, сул чөлөөтэй ажлын байр 53, шинэ ажлын байр 12, ажил олгогч 4 иргэний мэдээллийг мэдээллийн санд оруулав.

Солонгос хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэлийг 3 дугаар сарын 15-18-ны хооронд зохион байгуулахад 160 иргэн бүртгүүлж, цахим файлыг ХХҮЕГ-т хүргүүллээ.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Аймгийн хэмжээнд нийт 13928 тэтгэвэр авагчид 3 дугаар сард 4.6 тэрбум төгрөгийн тэтгэвэрийг олгосон. НДХ-ийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 3 удаа зохион байгуулж, 166 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 27 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 130 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 9 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг цуцлав.

Төрөөс тэтгэвэрийн талаар баримтлах бодлого, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, даатгалын цахим үйлчилгээг сурталчлах зорилгоор “НҮБ-ын хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээ бий болгох төслийн чадавхжуулах сургалт”-ыг Эрдэнэ сум, УБХ, АНЭ, Ахмадын холбоо зэрэг төрийн болон ТББ-ын 198 иргэн, даатгуулагчид хийж, мэдээллэл өглөө.

Эрүүл мэндийн үйлчилгээ: Нүүдлийн амбулаторийн үзлэгийг 12 суманд зохион байгуулж, нарийн мэргэжлийн эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 7561 иргэн, шинжилгээнд 1601 иргэн хамрагдлаа.

ажиллан үзлэг, оношилгоо хийж, халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг эрчимжүүлэн Танита аппаратаар иргэдийн биеийн найрлагыг тодорхойлж, эрүүл мэндийн зөвлөгөө өгч, багийн эмч нартай хамтран артерийн гипертензи, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгууллаа.

Жирэмсний хяналтын чанарыг үнэлэх “Гэр үнэлгээний аргачлал”-ыг нэвтрүүлэх бүсчилсэн сургалтыг Мөнгөнморьт, Бүрэн, Сэргэлэн сумдын Эрүүл мэндийн төвд зохион байгуулж, 9 сумын 72 эмч, мэргэжилтнийг хамрууллаа. НЭМҮТ-тэй хамтран “Нялх, бага насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл эхийн хооллолтын зөвлөгөө” сэдэвт Төвийн бүсийн аймгуудын сургалтыг 2019 оны 03 дугаар сарын 18-20-ны өдөр зохион байгуулсан. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 10 төрлийн видео шторк бэлтгэн цахим хуудсаар сургалчилсан.

МУЗГ-аас хэрэгжүүлж буй “Элэг бүтэн-Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн Яам, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/ хамтран “Эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эрүүл мэндийн ажилтнуудын вируст хепатитийн оношилгоо, илрүүлэг, урьдчилан сэргийлэлт, эмчилгээний чадавхийг сайжруулах” сургалтыг 85 эмч, мэргэжилнүүдэд хийлээ.

Сувилахуйн шаталсан бакалаврын ангийн оюутан сувилагч 11 хүн ОХУ-ын Буриадын БНУ-ын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан.

Баян, Баяндэлгэр сумдад эндсэн хүүхдийн магадлан хэлэлцэх зохион байгуулж, “Хатгалгаа өвчний хүндрэл түүнээс урьдчилан сэргийлэх” сэдвээр сургалт, дадлага сургуулилт хийв.

Монголын бүдүүн шулуун гэдэсний мэс заслын эмч нарын нийгэмлэгтэй хамран БНСУ-д болсон “Бүдүүн шулуун гэдэсний мэс засал” сэдэвт дадлага сургалтад аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэс заслын их эмч Н.Биханзрагчааг хамруулсан.

Дэлхийн эмч нарын өдрийн угтан эмч, мэргэжилтний дунд спортын нөхөрсөг тэмцээн, “Эмч зөвлөж байна” видео бичлэгийн уралдаан, “Яг түүн шиг” шоу зэрэг тэмцээн уралдааныг амжилттай зохион байгууллаа. Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрийн хүрээнд “Сүрьеэгүй Төв аймгийн төлөө хамтдаа” уриан дор өдөрлөг зохион байгуулж иргэд, олон нийтэд артерийн даралт хэмжих, витаминжуулах, биеийн жингийн индекс тодорхойлох, цусан дахь сахар тодорхойлох шинжилгээ, эрүүл мэндийн сургалт сурталчилгаа, зөвлөгөө зэрэг үйлчилгээг үзүүлээ.

### **Зургаа. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд**

ХАА-н чиглэлээр: Атрын 60 жилийн ойг тэмдэглэх аймгийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж, төрийн одон медалиар шагнагдах 300 гаруй иргэдийн судалгаа гарган ХХААХҮЯ-нд хүргүүллээ. Сумдын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийн сургалт зөвлөгөөнийг зохион байгуулан, мэдлэг, ур чадварыг ахиулсан.

2019 оны хаврын тариалалтын захиалгыг сум, аж ахуйн нэгжээс ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлого зохицуулалтын газарт хүргүүллээ. Аймгийн хэмжээнд 2019 оны хаврын тариалалтад 13,8 мян тонн улаан буудай үр шаардлагатай бөгөөд 8,3 мян тонн үрийн дутагдалтай байна.

Төсөл хөтөлбөрийн хамтын ажиллагааны хүрээнд “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийн байгууллагад *Газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, Үр сортын тогтолцоог сайжруулах, Газар тариалангийн эрсдэлийн менежментийг сайжруулах, зохистой дадлыг хэвшүүлэх, Газар тариалангийн салбарын ажилтныг чадавхижуулах сургалт*-ын саналыг хүргүүлсэн. Шууд харилцаат Япон улсын Тоттори мужийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан Жаргалант суман дахь “Томоко” ОНӨҮГ-ын Бордооны үйлдвэрийн “Удирдлагын гэрээ”-ний хэрэгжилтийг дүгнэж, тоног төхөөрөмжийг хэсэгчлэн дахин тендер зарлахаар шийдвэрлэлээ.

Тайлант хугацаанд 11 сумын 25 ногоочин 5,6 сая төгрөгийг өртөг бүхий хүлэмжийн 30 нийлэг хальс нийлүүлсэн. Мөн 3 сумын 4 аж ахуйн нэгж, иргэнд 118,4 сая төгрөгийн өртөг бүхий 37 ширхэг Зуны хүлэмжийг 30 хувийн урьдчилгаа төлүүлэн, 48 сарын хугацаатай зээлээр олгов.

“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулагдах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, ажил эрчимжүүлэх уулзалт зохион байгуулагдсан. Аймгийн “ЖДҮ-27” үйлдвэржүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт хийж, байгуулагдах үйлдвэр, цехийн нарийвчилсан судалгаа гаргав. 2016-2018 онд шинээр байгуулагдсан, үйл ажиллагаагаа өргөтгөсөн 75 үйлдвэрийн мэдээлэл, судалгаа гаргаж ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд төллөх насны хээлтэгч малын 32,8 хувь буюу 711950 толгой хээлтэгч мал төллөж, 712831 толгой төл бойжиж байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 26 суманд 36 инженерийн хийцтэй худаг шинээр барих тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажлыг эхлүүлэв. Батсүмбэр суманд хэрэгжүүлэх Дэлхийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас хэрэгжүүлж буй “Уур амьсгалд ухаалаг хандах, МАА-н тогтвортой хөгжлийг турших нь” төслийн хүрээнд “Ноос боловсруулах үйлдвэрлэлийн өртгийн сүлжээ” сэдэвт сургалтыг зохион байгуулж, бэлтгэн нийлүүлэгч, мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Мал эмнэлгийн салбарын өнөөгийн хэрэгцээ, шаардлага, баримталж буй бодлого, мал эмнэлгийн гэрчилгээ, баталгаажуулалтын системийг нэвтрүүлэлт, лабораторийн сүлжээ, нэгдсэн мэдээллийн сангийн талаар чиглэл өгөх зорилгоор “Малын эмчийн нарын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 120 эмч, мэргэжилтнүүдийг хамрууллаа.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 12 төрлийн вакцинжуулалтад 1467,8 мян.мал хамруулахаар төлөвлөж, “Биокомбинат” УТҮГ-тай гэрээ байгуулав. Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 200 мян.тун буюу 200 мян.төл мал хамруулахаар 27 сумын 92 мал эмнэлгийн нэгжид хуваарилалт хийж, вакцинжуулалтын бэлтгэл хангасан.

Лүн сумын МЭХЦХЦ-ийн хяналтын цэгээс адуу 230, үхэр 13, хонь 569, ямаа 64 толгой, мах, махан бүтээгдэхүүн 91.1 тн, 51949 арьс зэрэг бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг шалган, постоор нэвтрүүлж 118 машин, 140 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэл хийлээ.

Хөрөнгө оруулалт, Худалдан авах ажиллагааны үйлчилгээ: 2019 оны 03 сарын 26-ны байдлаар аймгийн хэмжээнд **41793,5 сая** төгрөгөөр санхүүжих төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 32434,1 сая төгрөгөөр санхүүжих 36 төсөл, арга хэмжээ байгаагаас эрх шилжин ирсэн 24466,1 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн хөгжлийн сангаар 2452,5 сая төгрөгөөр 24 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн шилжих үлдэгдлээр 3500,0 сая төгрөгөөр 18 төсөл, арга хэмжээ
- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 466,5 сая төгрөгийн 11 арга хэмжээ
- Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 718,7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ төлөвлөж

Аймгийн ТЭЗ-ийн 2019 оны хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn), [www.khural.mn](http://www.khural.mn) цахим хуудас, Монголын үнэн сонины 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 002 дугаарт нийтлүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангалаа. Мөн 27 сумын ТЗ-чийн худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) байршуулан Сангийн яамны ХАА-ны газраар батлуулав.

Барилга, хот байгуулалтын чиглэлээр: 2019 оны 1 дүгээр улиралд 21 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулж баталсан бөгөөд тайлант сард 15 архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулан баталсан. Мөн 27 барилгын зураг төсөлд зөвшөөрөл олгосноос тайлант сард 9 барилгын эх загвар болон ажлын зураг төслийг хянаж зөвшөөрөл олгов.

МУЗГ-ын 2018 оны 68, 171 дүгээр тогтоолын дагуу 3 дугаар сард 4 барилга байгууламжийн ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгосон. Мөн ЗГ-ын 2018 оны 317 дугаар тогтоолыг баримтлан аймгийн хэмжээнд 2 барилга байгууламж ашиглалтад өгч, Хот байгуулалтын сүлжээний мэдээллийн санд 1 барилга байгууламжийг бүртгэн акт өгсөн.

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн програм хангамжийг аймагт хүлээлгэн өгсөн бөгөөд программын зааварчилгаа ач холбогдол, цаашдын чиг хандлагын талаар 2 өдрийн сургалт зохион байгууллаа.

Мөнгөнморьт, Архуст, Баянцагаан, Сэргэлэн, Өндөрширээт сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврын төслийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хянуулахаар хүргүүлэв.

Хот, суурин газрын өнгө төрх, гэрэлтүүлэг чимэглэлийг сайжруулах зорилгоор байгууллага, аж ахуйн нэгжийн барилгыг фасадны гэрэлтүүлгийн 3d зургаг боловсруулах, материалын тооцоо гаргах ажлын хүрээнд Монгол туургатан театрын барилга, Аймгийн ЗДТГ-ын барилга, Төр захиргааны 2-р байр, ГХБХБГ-ын гадна гэрэлтүүлгийн зураглал гаргасан.

Орон нутгийн өмчийн чиглэлээр: Төрийн болон орон нутгийн өмчит 223 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээ, санхүүгийн болон статистик мэдээ тайланг нэгтгэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн.

Төв аймагт 1991-1996 онд хувьчлагдсан аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгө, хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуйн мал, эд хөрөнгийн судалгаа, тайлан мэдээг гаргаж ЗГХЭГ-т хүргүүлээд байна.

Хүмүүн цогцолбор сургуулийн хичээлийн “В” байр, “Төв Чандмань-ДЭХГ” ОНӨААТҮГ-ын хуучин дулааны станцын барилга байгууламж, газар, тоног төхөөрөмжийг худалдах зорилгоор мэргэжлийн байгууллагаар зах зээлийн бодит үнийг тогтоолгон тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэв.

Газрын харилцааны үйлчилгээ: Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах Шинэ нисэх онгоцны буудлын зориулалтаар тусгай хэрэгцээнд авсан 12000 га газартай давхцал бүхий иргэн, аж ахуй нэгжийн судалгаа гарган хяналтын хэмжилт хийсэн. Мөн сумын нутаг дэвсгэрт байрлах “Майдар” хотын бүтээн байгуулалтын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 12000 га газартай давхцал бүхий 535 нэгж талбарын хээрийн судалгааг хийлээ.

Зуунмод сумын 2019 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 12 нэгж талбар буюу амины орон сууцны зориулалтай газар-11 байршилд, худалдаа үйлчилгээний цогцолбор газрын зориулалтаар-1 байршилд газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг 2019 оны 03 дугаар 20-ны өдөр танхимаар зохион байгуулахад 171 оролцогч бүртгүүлж 100 хувь ирцтэй оролцсон. Дуудлага худалдаанд нийт 419,7 сая төгрөгийн орлого бүрдүүлэх боломжтой болсон бөгөөд ялагчид гэрээ байгуулснаас хойш 14 хоногийн дотор төлбөрийг бүрэн төвлөрүүлнэ.

Аймгийн ИТХ-аар газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд Газрын харилцааны чиглэлийн 2018 оны тайланг дүгнүүлж, 2019 оны газрын харилцааны чиглэлийн төлөвлөгөөг батлууллаа.

Байгаль орчны чиглэлээр: "Байгаль орчныг хамгаалах тухай", "Ойн тухай", "Гамшгаас хамгаалах тухай" хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартыг үндэслэн хяналт, шалгалт хийж, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, хаврын хуурайшилтын үед эргүүл шалгалтын бэлэн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангахаар аймгийн Засаг даргын 2019 оны

03 дугаар сарын 05-ны өдрийн удирдамжийн дагуу БОАЖГ, МХГ, ОБГ хамтран ой бүхий 13-н суманд ажилласан.

Батсүмбэр суманд мод бэлтгэл явуулдаг ААН-ийн тусгаарлалтын талбайд шалгалт хийхэд технологийн горим зөрчсөн "Толийн гарам" ХХК-д МХГ-аас 1.5 сая төгрөгийн торгуул ногдуулж зөрчлийг арилгуулсан. Хууль бус мод бэлтгэл хийж байна гэсэн мэдээллийн мөрөөр Жаргалант суманд 2019 оны 03 дугаар сарын 9-10-ны өдрүүдэд ажиллаж, газарт нь хэмжилт хийн 53.3 сая төгрөгийн экологи эдийн засгийн үнэлгээ тооцсон дүгнэлт гаргаж, хуулийн байгууллагад шилжүүллээ.

Усан сан бүхий газар болон улс, орон нутгийн чанартай авто зам дагуу нийтийн цэвэрлэгээ аймгийн хэмжээнд зохион байгуулахад 56 аж ахуйн нэгж, 27 нөхөрлөл, 596 иргэд оролцон 287.2 тн хог хаягдал, 35ш малын сэг зэмийг цэвэрлэж 473.0 мян.төг зарцуулсан байна. Мөн Угтаалцайдам, Сэргэлэн сумд төвлөрсөн хогийн цэгийн талбайг 1.2 га-р багасгаж, 1390 тн хогийг дарж булшлах ажлыг зохион байгуулав.

Дэлхийн усны өдрийг тохиолдуулан "Иргэдээ сонсох өдөрлөг"-ийг 2019.03.22-нд ТҮНТ-д зохион байгуулж, БОАЖГ-ын мэдээлэл, цэвэр усны зохистой хэрэглээ, хуванцар савны хэрэглээ, хөрсний бохирдол болон гялгар уутны хэрэглээний талаар иргэдэд мэдээлэл өгч, санал солилцсон. Өдөрлөгийн үеэр "Төв-Чандмань" ДЭХГ-аас "Усаа зохистой хэрэглээ" гар зураг болон эссэ бичлэгийн уралдаан зарлахад 300 гаруй гар зураг, 52 эссэ ирж, шилдгээр шалгарсан 9 хүүхдэд урамшуулал гардуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын албан хаагчид, бичиг уурхай эрхлэгч, нөхөрлөлүүдийн нийт 120 төлөөлөл оролцсон нэгдсэн сургалт, семинарыг 2019.03.04-05 өдрүүдэд Баянчандмань суманд "Хариуцлагатай бичил уурхай" болон "Газрын доорх усны менежмент" сэдвийн хүрээнд амжилттай зохион байгуулсан.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: 2019 оны I улирлын байдлаар 459 согтууруулах ундааны цэг, салбар үйл ажиллагаа явуулж байгаа нь 2016 онтой харьцуулахад 21,8 хувиар буурсан байна. Худалдааны 372 цэг, нийтийн хоолны 43 Амралт аялалын жуулчлалын 44 цэг, газар үйл ажиллагаа явуулж байна.

Баянчандмань суманд зохион байгуулагдсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийн үеэр худалдаа, нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч 18 иргэнд "Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019", "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага" сэдвээр сургалт хийж, 2 үйлчилгээний цэгт үнэлгээ хийж тохиролын гэрчилгээ олгон 10 жин шалган баталгаажуулав.

### **Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:**

МУЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн **112** зорилт **318** хэрэгжүүлэх арга хэмжээ дунджаар **86,49** хувьтай, үүнээс 100%-230, 70%-121, 40%-22, 0-1, үнэлэх боломжгүй- 4; аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн **141** зорилтын **526** арга хэмжээ дунджаар **93.28** хувьтай, үүнээс 100%-421, 70%-67, 40%-15, 0-5, үнэлэх боломжгүй 18 дүгнэгдэж аймгийн ИТХ-ын 12-р хуралдаанаар хэлэлцүүлэн ЗГХЭГ-т хүргүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны үнэлгээний дүнг ЗГХЭГ-т хүргүүлэв. /Үүнд: 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, 2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 3.Эдийн засаг, нийгмийг хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ, 4.Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, 5. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор



суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт, 6.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ, 7.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ, 8. Хэрэглэгчийн үнэлгээний тайлан/

Аймгийн ЗДТГ-т ISO 9001:2015 олон улсын стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд 4 өдрийн сургалтад бодлогын 6 хэлтэс, 3 албадын давхардсан тоогоор 82 ажилтан, албан хаагчдыг хамруулав.

### **Найм. Цэргийн штабын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын 2019 оны А/98 дугаар захирамжаар “Монгол цэргийн өдөр” орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны яруу алдарт 98 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу зохион явууллаа.

Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өрөгжүүлэх, үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, албан хаагчдын цэрэгжлийн ур чадврыг дээшлүүлэх, орон нутгийн үйл ажиллагаанд хамтран дэмжлэг үзүүлэх зорилгоор “Эх орны төлөө 2019” цогцолбор арга хэмжээний хүрээнд Монгол Улсын маршал Х.Чойбалсангийн нэрэмжит Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 016 дугаар бригадтай хамтран аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн цэргийн байгууллага болон хуулийн байгууллагуудын эмэгтэй алба хаагчдын дунд “Мөрдэс гоёсон бүсгүй” урлагийн тэмцээн, спортын 4 төрөлт тэмцээн, сумын заан болон түүнээс доош цолтой 64 хүчит бөхийн барилдаанд зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, баг тамирчдыг алдаршуулан урамшуулсан.

Мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуужилыг сорих аймгийн Засаг даргын нэрэмжит марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээнд 8 байгууллагын 80 гаруй албан хаагчид оролцсон нь ур чадвараар өрсөлдлөө.